



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 07 сарын 21 өдөр

Дугаар А/288

Улаанбаатар хот

Г

Г

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйл, 14 дүгээр зүйлийн 14.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3, 19.20.8, Эрүүл мэндийн яамны "Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс"-ын 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох байгууллагын нэрсийг хавсралтаар баталсугай.
2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Оюунчимэг/-т үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д даалгасугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 07 сарын 27-ны өдрийн
дугаар тушаалын хавсралт
288



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХ БАЙГУУЛЛАГЫН
НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА**

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн хугацаа
1	Үүлс дэл ХХК	Биологийн идэвхт бүтээгдэхүүн үйлдвэрлэх	3 жил
2	Нони ХХК	Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	3 жил
3	И элди эй ХХК	Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, оношлуур импортлох, ханган нийлүүлэх	3 жил
4	Зэндмэнэ гэрэл ХХК	Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, оношлуур импортлох, ханган нийлүүлэх	3 жил
5	Эй ёү жи ложистикс ХХК	Биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	3 жил